



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 450

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авах,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 55 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн өмчөөс шилжүүлсэн 16,720,000.00 (арван зургаан сая долоон зуун хорин мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Тагнуулын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Тагнуулын ерөнхий газрын дарга П.Одонбаатар, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга С.Баясгалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Дархан-Уул аймгийн өмчөөс төрийн өмчид хөрөнгө шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

300800

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 09
дүгээр сарын 24-ны өдрийн 450
тоот тогтоолын хавсралт

**Дархан-уул аймгийн өмчөөс Тагнуулын ерөнхий газрын балансад
шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	тоо шир хэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөгөөр/
1	Тоёото Приус-20 маркийн, ДАА 25-44 улсын дугаартай, арлын дугаар- JNHW203564177, суудлын автомашин	2010	ш	1.00	167,200,000.00	167,200,000.00
				1 (нэг)		16,720,000.00 (арван зургаан сая долоон зуун хорин мянган)